# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 08 өдөр Дугаар 06 Улаанбаатар хот

“Өсвөрийн сэргийлэгч” сайн дурын
бүлгэмийн ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Монгол Улсын хууль, зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/252, А/253 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн “Өсвөрийн сэргийлэгч” сайн дурын бүлгэмийн ажиллах журмыг нэгдүгээр, “Өсвөрийн сэргийлэгчийн таних тэмдгийн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хэрэгжилтийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд жил бүр тайлагнаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү журмыг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100035

D:\2018 on\ Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын
08-ны өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН “ӨСВӨРИЙН СЭРГИЙЛЭГЧ” САЙН ДУРЫН БҮЛГЭМИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилго бүхий “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” \цаашид “Бүлгэм” гэх\ ажиллуулахад энэхүү журмыг мөрдөнө.

## Хоёр. Бүлгэмийн зохион байгуулалт, удирдлага

2.1. Өмчийн хэлбэр харгалзахгүй ерөнхий боловсролын сургуульд Өсвөрийн сэргийлэгч бүлгэм ажиллана.

2.2. Бүлгэмийн гишүүд нь тухайн сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын төлөөллөөс бүрдэх бөгөөд бүлгэмийн удирдагч нь сургуулийн нийгмийн ухааны багш байх ба сургуулийн нийгмийн ажилтан ерөнхий удирдлагаар ханган ажиллана.

2.3. Бүлгэмийн гишүүдийг тухайн суралцагчийн өөрийн хүсэлт, түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл болон ангийн хамт олны саналыг үндэслэн сонгож, сургуулийн захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.

2.4. Бүлгэмийн гишүүн нь анги хамт олныхоо дунд нэр хүндтэй, бусдад үлгэр дууриал болохуйц мөн цаашид хууль, эрх зүйн чиглэлээр суралцах хүсэл эрмэлзэлтэй сурагч байна.

2.5. Бүлгэмийн үйл ажиллагааг бүтэн жилээр төлөвлөж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар батлуулна. Бүлгэмийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн сургууль тус бүр дээр бүлгэмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан сургуулийн захирлын тушаалаар батлуулна.

2.6. Бүлгэмийн үйл ажиллагаа нь жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний хугацаанд явагдана.

2.7. Бүлгэмийн гишүүн нь батлагдсан таних тэмдгийг зүүж хэрэглэнэ. Таних тэмдгийг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл олгоно. Бүлгэмийн гишүүнээс чөлөөлөгдөх тохиолдолд таних тэмдгийг сургуулийн захиргаанд буцаан өгнө.

2.8. Бүлгэмийн гишүүн нь хүсэлт гаргасан, сургуулиа төгссөн, шилжсэн, сахилгын зөрчил гаргасан, гэмт хэрэг зөрчил үйлдсэн нь түүнийг чөлөөлөх үндэслэл болно.

2.9. Бүлгэмийн удирдагч багш нь бүлгэмийн үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гарган сургуулийн удирдлагад танилцуулан, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, харьяа нутаг дэвсгэрийн боловсролын хэлтэст тус тус хүргүүлнэ.

2.10. Бүлгэмийн удирдагч багшийг өөрийн хүсэлтийг үндэслэн захирлын тушаалаар томилж, чөлөөлнө.

2.11. Бүлгэм нь хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн талаар мэдээллийн самбар болон бусад арга хэрэгслээр олон нийт, эцэг эх, суралцагч, сургуулийн удирдлага, багш нарт мэдээлэх, сурталчилах ажлыг зохион байгуулна.

Гурав. Бүлгэмийн үйл ажиллагааны чиглэл

3.1. Бүлгэм нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Сургуулийн ойр орчимд учирч болзошгүй эрсдэлийг судлах, тодорхойлох, хичээл эхлэх, тарах, завсарлагааны цагт сургууль дотор, дулааны улиралд сургуулийн ойр орчимд сайн дурын эргүүл хийх.

3.1.2. Холбогдох хууль тогтоомж болон сургуулийн дотоод дэг журмыг тогтмол сурталчилан таниулах, дагаж мөрдөх, биелүүлэх талаар сурагчдад шаардлага тавьж хэрэгжилтийг хангахаас гадна нөлөөллийн ажил зохион байгуулах.

3.1.3. Суралцагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төрөл бүрийн уралдаан, тэмцээн, уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг сургуулийн удирдлага, эцэг эхийн зөвлөл, тухайн хорооны цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

3.1.4. Эрсдэлт нөхцөлт байгаа хүүхдийн талаар мэдсэн, илрүүлсэн тохиолдолд нийгмийн ажилтан, сургуулийн захиргаа болон холбогдох байгууллага /108, 102.../-д нэн даруй мэдэгдэх.

3.1.5. Сурагчдын өмнө тулгамдаж байгаа зарим асуудал, сургуулийн орчинд үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, холбогдох дүрэм журмын биелэлтийн талаар хэлэлцэн, хэрэгжүүлэх ажлын саналыг сургуулийн захиргаа, удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх.

3.1.6. Сургууль дээр зохион байгуулагдаж буй нийтийн арга хэмжээний үеэр дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд сургуулийн захиргаатай хамтран ажиллах.

Дөрөв. Бүлгэмийн гишүүдийн эрх, үүрэг

4.1. Бүлгэмийн гишүүн дор дурдсан эрхтэй байна.

4.1.1. Холбогдох хууль тогтоомж болон сургуулийн дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх талаар сурагчдад шаардлага тавьж хэрэгжилтийг хангуулах, сурагчдад мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах.

4.1.2. Суралцагчийн болон сургуулийн дотоод дүрэм, журмын хэрэгжилтийг удаа дараа зөрчсөн суралцагчийн талаар удирдагч багш болон сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэх.

4.2. Бүлгэмийн гишүүн дор дурдсан үүрэгтэй.

4.2.1. Энэхүү журамд заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа сургуулийн нийгмийн ажилтан болон бүлгэмийн удирдагч багшаас өгсөн хууль ёсны үүрэг, зааварчилгааг мөрдөх.

4.2.2. Холбогдох хууль тогтоомж болон сургуулийн дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх талаар сурагчдад танилцуулга, мэдээлэл хийх.

4.2.3. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ мэдээллийг удирдагч багш, сургуулийн нийгмийн ажилтан болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх.

4.2.4. Бусдыг үндэс угсаа, хэл соёл, арьсны өнгө нас, хүйс, нийгмийн байдал, эрхэлсэн ажил шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахгүй байх.

4.2.5. Үүрэг гүйцэтгэх үедээ олж мэдсэн, гэмт хэрэг зөрчилд холбогдсон болон хохирсон хүүхдийн талаарх болон хувь хүний нууцтай холбоотой мэдээ мэдээллийг бусдад задруулахгүй байх.

Тав. Бүлгэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

5.1. Сургуулийн захирал нь бүлгэмийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй ажиллана.

5.1.1. Бүлгэмийн зохион байгуулж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулах. /Дүүргийн ГХУСАЗСЗ, Боловсролын хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс/

5.1.2. Бүлгэмийн тайлан, санал, мэдээллийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх

5.1.3. Бүлгэмийн гишүүдийг сургаж дадлагажуулах, чадваржуулах, туршлага судлуулах ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах.

5.2. Цагдаагийн байгууллага нь бүлгэмийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй ажиллана.

5.2.1. Бүлгэмийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, шаардлагатай гарын авлага материалаар хангах, сургалт хамтран зохион байгуулах,

5.2.2. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран оролцох,

5.2.3. Бүлгэмийн гишүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулах

5.3. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь бүлгэмийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр дараах чиг үүрэгтэй ажиллана.

5.3.1. Бүлгэмийн гишүүдэд эрхзүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах

5.3.2. Бүлгэмээс зохион байгуулж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран оролцох

5.3.3. Харьяа нутаг дэвсгэрийн бүлгэмийн ажлын төлөвлөгөө, тайлан мэдээнд бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, үнэлж урамшуулах

5.3.4. Бүлгэмүүдийн дунд туршлага солилцох уулзалт, өдөрлөг, уралдаан, тэмцээн, сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, сурталчилах

## Зургаа. Бүлгэмийн гишүүдийг урамшуулах

6.1 Бүлгэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бусдыгаа манлайлан ажилласан гишүүнийг сургуулийн захиргаанаас сургуулийн дотоод дүрэм, журмын дагуу урамшуулах болон дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шагналд нэр дэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

6.2. Журмын дагуу идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бүлгэм, түүний гишүүдэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажилласан багш, сурагч, эцэг эхийг боловсролын болон цагдаагийн байгууллагын саналыг харгалзан дүүрэг орон нутгийн  Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл шагнаж урамшуулж болно.

6.3. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын “Өсвөрийн сэргийлэгч” сайн дурын бүлгэмийн ажлын тайланг жилд нэг удаа дүгнэж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шагнаж урамшуулна.

6.4. Сургуулиудын бүлгэмүүдээс ирсэн тодорхойлолтыг үндэслэн дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шийдвэрээр “Өсвөрийн сэргийлэгч” хүндэт тэмдгээр шагнуулах хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилж, шагнана.

## Долоо. Бусад

7.1.Бүлгэмийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

7.2.Бүлгэмийн сурагчдаас идэвх санаачилгатай, манлайлан ажилласан, хууль сахиулахын сургуульд суралцах хүсэлтэй сурагчдад дэмжлэг үзүүлнэ.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын
08-ны өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ТАНИХ ТЭМДГИЙН ЗАГВАР

1. Өсвөрийн сэргийлэгч таних тэмдгийн суурь өнгийг амжилт, оюун ухаан, сэтгэн бодох чадвар, авьяасыг билэгдэж шар өнгөөр хийж, “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” гэсэн үгийг итгэлцэл үнэнч байдлыг илтгэдэг цэнхэр өнгөөр сийлж, тэмдэгийн голд зургаан хошуу дүрс дээр цагдаагийн байгууллагын билэг тэмдэг болсон шонхор шувууг байрлуулна.

2. Таних тэмдэгийн хэмжээ: Дотор тойргийн диаметр 5 см, гадна тойргийн диаметр 6 см байна.

3. Таних тэмдгийг энгэрт зүүж хэрэглэнэ.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 08 өдөр Дугаар 07 Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний түгжрэл саатлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дэд зөвлөлийн дарга:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга

Зөвлөлийн гишүүд:

Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын дарга /*зөвшилцсөнөөр*/

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дарга

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 2 дугаар хэлтсийн дарга

Нийслэлийн авто замын хөгжлийн газрын орлогч дарга /*зөвшилцсөнөөр*/

Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Боловсролын хэлтсийн дарга

1150100021

“Чингэлтэйн тохижилт үйлчилгээний компани”-ий захирал

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг дэд зөвлөлийн дарга /А.Дамцагдорж/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Хурлын Ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА Д.БАТ-ЭРДЭНЭ

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 08 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

**МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ ТЕХНИКЧ ЦОЛ”-ООР**

| | | |
|---|---|---|
| 1. | Рэнцэнийн Гонгор | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан |

**МОНГОЛ УЛСЫН “ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ”-ООР**

| | | |
|---|---|---|
| 1. | Увшийн Заяат | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны өндөр настан, Глобаль Бизнес Линк компаний зөвлөх |

**МОНГОЛ УЛСЫН "ГАВЬЯАТ БАГШ ЦОЛ”-ООР**

| | | |
|---|---|---|
| 1. | Дамдинсүрэнгийн Дагиймаа | Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны ахмад настан, Монгол хэл-уран зохиолын багш |

**"ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ООР**

| | | |
|---|---|---|
| 1. | Гөлгөний Хумаа | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв-4 Ахмад настан |

**"ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ООР**

1150100013

D:\2018 on\ Togtool

| | | |
|---|---|---|
| 1. | Наваанжанцангийн Балжинням | Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны ахмад настан, Үйлдвэрчний холбооны дарга |

## "АЛТАН ГАДАС ОДОН"-ООР

| | | |
|---|---|---|
| 1. | Жанцангийн Нина | Хориулт ХХК-д кабелын техникч |
| 2. | Санжаагийн Батмөнх | ОСНААУГ-ын инженерийн байгууламж хариуцсан дэд дарга бөгөөд Ерөнхий инженер |
| 3. | Даажингийн Баяраа | ОСНААУГ-ын инженерийн байгууламж хариуцсан дэд дарга бөгөөд Ерөнхий инженер, Техник үйлчилгээний хэлтсийн дарга |
| 4. | Жавзмаагийн Алтаншагай | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 4-ийн Ахмад настан |
| 5. | Доржийн Гантулга | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Баруун түгээх төвийн Сантехникийн слесарь |
| 6. | Ноосройн Баттулга | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Төв түгээх төвийн Машинист |
| 7. | Найдангийн Баасанжав | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 9-ийн Сантехникийн засварчин |
| 8. | Цэрэнсамбуугийн Бадамноров | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 2-ын Дарга |
| 9. | Эрдэнэхүүгийн Цогтгэрэл | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 10-ын Дарга |
| 10. | Сосорбарамын Энхтуяа | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 9-ийн Сантехникийн засварчин |
| 11. | Бойжирын Доржханд | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 12-ын Борлуулалтын байцаагч |
| 12. | Дашдэндэвийн Энх-Ялалт | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 13-ын Ахлах инженер |
| 13. | Найдангийн Отгонбилэг | Хэрэглэгчдэд үйлчлэх төв 14-ийн Сантехникийн инженер |

| | | |
|---|---|---|
| 14. | Жамбалын Нэргүй | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан |
| 15. | Лувсанчүлтэмийн Жавзмаа | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны өндөр настан |
| 16. | Чүлтэмийн Нэргүй | Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны өндөр настан |
| 17. | Цэндийн Нарантуяа | Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны өндөр настан |
| 18. | Сангиринчингийн Дагиймаа | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны өндөр настан |
| 19. | Майдаржавын Энхбаатар | Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн шинжээч |

## "ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ИАР

| | | |
|---|---|---|
| 1. | Гэндэнжавын Дүүрэнбал | Хөх цацал ХХК-ний барилгын инженер |
| 2. | Бөхчулууны Тунгалаг | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Хүний нөөцийн мэргэжилтэн |
| 3. | Янжинхорлоогийн Гүндсамбуу | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Нярав, эд хариуцагч |
| 4. | Долгорын Нямсүрэн | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Орон сууц хувьчлах товчооны Нягтлан бодогч |
| 5. | Аюушжавын Даваахүү | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Төв түгээх төвийн Инженер |
| 6. | Дагвадоржийн Мандах | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Баруун түгээх төвийн Машинист |
| 7. | Баасандашийн Дугар | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Баруун түгээх төвийн Сантехникийн инженер |
| 8. | Жавзандолгорын Бат-Эрдэнэ | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Баруун түгээх төвийн Сантехникийн засварчин |
| 9. | Пунцагийн Батсайхан | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Баруун түгээх төвийн |

| | | |
|---|---|---|
| | | Сантехникийн инженер |
| 10. | Тоохүүгийн Ганзориг | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Баруун түгээх төвийн Уул уурхайн инженер |
| 11. | Баасангийн Баяраа | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Баруун түгээх төвийн Уул уурхайн инженер |
| 12. | Түдэвдоржийн Баяраа | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Зүүн түгээх төвийн Сантехникийн инженер |
| 13. | Мандширын Лхагвасүрэн | Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газрын Зүүн түгээх төвийн Сантехникийн засварчин |
| 14. | Насанбатын Нарантуяа | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 1-ийн Ээлжийн инженер |
| 15. | Оросоогийн Алтанцэцэг | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 1-ийн Тооцооны нягтлан бодогч |
| 16. | Загдсүрэнгийн Зандармаа | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 2-ын Үйлчлэгч |
| 17. | Хүрлээгийн Уранчимэг | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 2-ын Ээлжийн инженер |
| 18. | Дамдинбазарын Батдорж | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6-ийн Цахилгааны инженер |
| 19. | Гомбын Дамиран | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6-ийн Хэсгийн инженер |
| 20. | Базаррагчаагийн Цоодол | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7-ийн Засварчин |

| | | |
|---|---|---|
| 21. | Осорын Гандолгор | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7-ийн Ахлах нягтлан бодогч |
| 22. | Шааримбуугийн Октябрь | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв7-ийн Ахлах инженер |
| 23. | Пүрэвдагвын Намсрай | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7-ийн Засварчин |
| 24. | Ивановын Очирсүрэн | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7-ийн Дуудлагын засварчин |
| 25. | Шаравын Гэрэлдулам | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 8-ын Борлуулалтын байцаагч |
| 26. | Баатарын Сосорбарам | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 9-ийн Ахлах инженер |
| 27. | Балжиннямын Ганхуяг | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 9-ийн Цахилгааны инженер |
| 28. | Гал-Очирын Мөнхзаяа | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 9-ийн Ээлжийн инженер |
| 29. | Балчиндоржийн Дарханбаатар | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 10-ын Сантехникийн засварчин |
| 30. | Содномын Оюунцэцэг | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 11-ийн Борлуулалтын байцаагч |
| 31. | Довчингийн Гантөмөр | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх Ахлах инженер |
| 32. | Бэгзжавын Баасансүрэн | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 13-ын Цахилгааны инженер |

| | | |
|---|---|---|
| 33. | Даваахүүгийн Ургамал | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 13-ын Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| 34. | Пунцагдоржийн Баатартуул | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 14-ийн Дарга |
| 35. | Лувсандашийн Оюунчимэг | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 14-ийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| 36. | Дугаржавын Дэлгэрмаа | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 14-ийн Ахлах нягтлан бодогч |
| 37. | Балдандоржийн Чулуун | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 15-ын Сантехникийн засварчин |
| 38. | Цэдэнгийн Сарантуяа | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 16-ийн Ээлжийн инженер |

ДАРГА Д.БАТ-ЭРДЭНЭ

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 08 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнахаар шийдвэрлэсүгэй.

2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Чандмань одон”-гоор шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100015

D:\2018 on\ Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын
08-ны өдрийн 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

| Д/Д | Овог нэрс | Эрхэлсэн ажил, мэргэжил | Регистрийн дугаар |
|---|---|---|---|
| 1 | Пунцагдоржийн Бүдсүрэн | Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны иргэн | Х361122119 |
| 2 | Тунсагийн Хулан | Чингэлтэй дүүргийн Мэргэжилийн хяналтын хэлтсийн Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч | ЦБ79082069 |
| 3 | Цээгээгийн Одгэрэл | Чингэлтэй дүүргийн Мэргэжилийн хяналтын хэлтэс Хүнсний чанар стандартын хяналтын улсын ахлах байцаагч | ХП63091008 |
| 4 | Дунгарын Отгонпүрэв | Чингэлтэй дүүргийн Мэргэжилийн хяналтын хэлтэс Эм био бэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч | РС92081609 |
| 5 | Жалелийн Сандугаш | Чингэлтэй дүүргийн Мэргэжилийн хяналтын хэлтэс Эрүүл мэндийн хяналтын улсын байцаагч | БЮ74081401 |
| 6 | Бадамхандын Нарантуяа | Чингэлтэй дүүргийн Мэргэжилийн хяналтын хэлтэс Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч | ИЭ77010304 |
| 7 | Ухнаагийн Оюунчимэг | Уртцагаан “Алаг даага” ХХК-ний оёдолчин | НЕ70091560 |
| 8 | Цогцолмаагийн Батжаргал | Уртцагаан “Алаг даага” ХХК-ний оёдолчин | НЭ83010561 |
| 9 | Гунгаажавын Мөнхцэцэг | Монголын өмгөөлөгчдийн холбоо Хуульч, өмгөөлөгч | ХП51122405 |
| 10 | Сум-Очирын Болдбаатар | “Ред лайн” ХХК-ний ерөнхий захирал | ЦЕ84102513 |
| 11 | Гаравын Баттогтох | Нийслэлийн авто замын хөгжлийн газрын орлогч дарга | ОЭ69060619 |
| 12 | Шагдарийн Дэмчиггарав | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны иргэн | Ш349071511 |
| 13 | Дуламын Нансалмаа | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны иргэн | ХП60070701 |
| 14 | Ванчигийн Төөгөө | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны өндөр настан | УС45122511 |
| 15 | Шагжын Бадам | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны иргэн | ХП50061404 |
| 16 | Норовсамбуугийн Наран-Очир | Батлан хамгаалахын их сургуулийн Удирдлагын академи Эрдэм шинжилгээ сургалтын албаны дарга | ЕП61050712 |
| 17 | Найдангийн | Батлан хамгаалахын их сургуулийн | ПЭ56012415 |

| | | | |
|---|---|---|---|
| | Энхбаялаг | БХУА-ийн захирал | |
| 18 | Баасангийн Нэргүй | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны иргэн | УБ81071000 |
| 19 | Жумдааны Нэргүй | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны иргэн | УШ55102602 |
| 20 | Дорждагвын Цолмонтуяа | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны иргэн | УЕ78111508 |
| 21 | Гэлэнхүүгийн Энхцэцэг | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны иргэн | УШ69120704 |
| 22 | Манжийн Цэцэгжаргал | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны иргэн | ПБ68011601 |
| 23 | Минжүүрийн Төмөрхүү | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны иргэн | ЦЗ57062504 |
| 24 | Дагванямын Энхтулга | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | ФД88090111 |
| 25 | Ганбатын Оюунханд | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | ДР74071205 |
| 26 | Цагаан-Очирын Бямбасүрэн | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | УХ53052871 |
| 27 | Даваагийн Оюундэлгэр | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | ХЗ54010902 |
| 28 | Жаргалын Цэрэн | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | ЦБ46082565 |
| 29 | Батаагийн Бат-Эрдэнэ | Цагдаагийн ерөнхий газрын нийгмийн хэв журам хамгаалах хэлтэс эргүүлийн цагдаа, хороо хариуцсан цагдаа, жижүүрийн цагдаа | УУ70102817 |
| 30 | Шаравын Дарьдулам | Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургуулийн багш | ХВ63060101 |
| 31 | Даянзагдын Эрдэнэбат | Монголын үйлдвэрчний эвлэл худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхий менежер | ЧР55111814 |
| 32 | Өлзийнхутгийн Энхцэцэг | Фэнгшүй холбооны зөвлөх | ЧН74112906 |
| 33 | Лхамсүрэнгийн Байгалмаа | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн | ЖЬ64051469 |
| 34 | Дүгэрсүрэнгийн Гомбосүрэн | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн | ВЭ52090779 |
| 35 | Бат-Өлзийгийн Бямбажав | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн | ВУ56022806 |
| 36 | Жамсрангийн Энхжаргал | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн | ХЛ76042463 |
| 37 | Эрдэнийн Даян | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн | ХН64042014 |
| 38 | Цэрэндоржийн Нямсүрэн | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн | ХН54091001 |
| 39 | Жамсранжавын Энхжаргал | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны иргэн | ЧЛ57123006 |
| 40 | Дэчингомбын Анна | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны иргэн | ЧО56032364 |

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын
08-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах хүмүүсийн нэрс

| Д/Д | Овог нэрс | Эрхэлсэн ажил, мэргэжил | Регистрийн дугаар |
|---|---|---|---|
| 1 | Анхтуяагийн Энэрэл | Чингэлтэй дүүргийн Мэргэжилийн хяналтын хэлтэс Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч | Ш385021007 |
| 2 | Лхаасүрэнгийн Мөнх-Очир | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | УЖ41070116 |
| 3 | Гэндэнгийн Бямба | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | УЖ45013005 |
| 4 | Сүрэнжавын Алтантулга | Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн | ХН68062273 |
| 5 | Цогбадрахын Цэнд-Аюуш | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны хэсгийн ахлагч | ХН58051802 |
| 6 | Лувсанжамцын Цэцэг-Өлзий | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны хэсгийн ахлагч | ХЛ59112663 |